

БАТЛАВ

БАТЛАВ

“БУЛГАН НЭТ” ХХК-ИЙН
.....Ч.ТҮВШИНБАЯР

.....

ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

202... оны ... сарын ...

№ .../...-...

Булган хот

Нэг талаас “Булган нэт” ХХК /хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар 0411004014, регистрийн дугаар 3187683/ (цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх), нөгөө талаас Булган аймгийн Булган сумын /регистрийн дугаар / (цаашид “Хэрэглэгч”, хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээгээр нийлүүлэгч нь Мобиком нэтворкс ХХК-ийн үндсэн сүлжээг ашиглан хэрэглэгчид интернэтийн үйлчилгээг чанартай хүргэх, түүний төлбөр тооцоо болон уг үйлчилгээтэй холбоотой үүсэх аливаа харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Интернэт үйлчилгээний нөхцөл, хугацаа

- 2.1 Үйлчилгээ үзүүлэгчийн Хэрэглэгч талд хүргэж буй интернэтийн урсгал (дугуйлах).
-(шилэн кабель)
-(wireless утасгүй холболт)
- 2.2 Хэрэглэгчийн Булган аймаг, Булган сум хаягтMbps хурдтай интернэт үйлчилгээг үзүүлнэ.
- 2.3 Хэрэглэгч дотоодын вэб хуудаснууд руу 24 цагаар хязгаарлалтгүй хурдаар холбогдоно.
- 2.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хүргэж байгаа 2.2-т заасан интернэтийн үйлчилгээний хурдыг Харилцаа холбооны зохицуулах хороо /ХХЗХ/-оос эрхлэн гаргасан speedtest.mn цахим хуудсанд хандан шалгах боломжтой ба үйлчилгээний талаар мэдээллийг 75991112, 99009529 утсаар илэрхийлэх боломжтой.
- 2.5 Үйлчилгээ үзүүлэгч нь төрийн байгууллага, ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудад уг үйлчилгээг үзүүлэхдээ домен нэрийн шүүлтүүр программ хангамж ашиглан насанд хүрэгчдэд зориулсан веб хуудсыг хаана.
- 2.6 Хэрэглэгчийн сонгож буй үйлчилгээний төрлөөс шалтгаалан гэрээний хавсралт 1-д заагдсан тоног төхөөрөмжүүдийг 2.2-т заасан хаягт суурилуулна.
- 2.7 Энэхүү гэрээг 20.... оны ...-р сарын ... -ны өдрөөс эхлэн ... жилийн хугацаатай байгуулав. Хэрэв аль нэг талаас гэрээг өөрчлөх санал гэрээ дуусахаас нэг сарын өмнө албан бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээ 1 /нэг/ жилээр сунгагдана.

Гурав. Үйлчилгээний төлбөр тооцоо

- 3.1 Гэрээний хавсралт 1-д заасан тоног төхөөрөмжийн төлбөр болон интернэт үйлчилгээний төлбөрийг гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн үйлчилгээ үзүүлэгч талд урьдчилан төлнө.
- 3.2 Үйлчилгээ үзүүлэгч сар бүрийн 15-ны дотор тухайн сарын интернэтийн үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэх ба хэрэглэгч дараа сарын 5-ны дотор нэхэмжилсэн төлбөрийг Төрийн банк **MN 52 0034 120000581942**, Хаан банкны **MN87 0005 00 5270528263** тоот дансанд бэлэн бусаар эсвэл бэлнээр төлнө.
- 3.3 Хэрэглэгч тал дансаар үйлчилгээний төлбөр тушаах тохиолдолд гүйлгээний утга хэсэг дээр гэрээ байгуулсан байгууллага болон хувь хүний нэрийг заавал бичнэ.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно

- 3.4 Хэрэглэгч нь энэхүү гэрээний 3.2-д заагдсан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хоног тутамд нийт төлбөрийн 0,1%-ийн алданги нөхөн төлнө.
- 3.5 Зөвхөн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс интернэт тасарсан тохиолдолд тасалдсан хугацааны интернэтийн төлбөрийг талуудын хамтарсан комиссын дүгнэлтийг үндэслэн хэрэглэгч талын тухайн сарын төлбөрөөс хасаж тооцох эсвэл дараа сарын төлбөрөөс суутгуулж болно.
- 3.6 Хэрэглэгч интернэт үйлчилгээ авч буй байршлыг сольж үйлчилгээгээ үргэлжлүүлэх тохиолдолд дахин суурилуулалтын төлбөр 40,000 төгрөг төлнө.
- 3.7 Үйлчилгээ үзүүлэгч талаас шалтгаалаагүй буюу хэрэглэгчийн дотоод сүлжээ, компьютер бусад төхөөрөмжийн техникийн гэмтэл саатлыг дуудлагаар засварлах үйлчилгээг үзүүлэх ба уг үйлчилгээг зөвхөн ажлын цагаар хийх бөгөөд цагийн 20,000 төгрөгийн үнэлгээтэй байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг, хариуцлага

- 4.1. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх үүрэг:
 - 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгч талаас интернэтийн төлбөрөө хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.
 - 4.1.2 Үйлчилгээний төлбөр төлөгдөөгүй хугацаанд хэрэглэгчийн интернэтийн үйлчилгээг үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс түр салгах эрхтэй байна.
 - 4.1.3 Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр төлөгдсөн өдрөөс эхлэн интернэт үйлчилгээг холбож хэрэглэгчээр бүртгэнэ.
 - 4.1.4 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний бүтэц, журам, нөхцөл, үнэ тарифт өөрчлөлт хийх эрхтэй бөгөөд энэ тухайгаа Хэрэглэгч талд хуанлийн 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.
 - 4.1.5 Хэрэглэгчээс үл хамаарах шалтгаанаар үйлчилгээнд саатал гарсан тохиолдолд Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх ба мэдэгдсэнээс хойш 48 (дөчин найман) цагийн дотор Үйлчилгээ үзүүлэгч нь гэмтэл саатлыг арилгах үүрэгтэй (давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд)
 - 4.1.6 Үйлчилгээ үзүүлэгч нь техникийн шинэчлэл, шугам сүлжээний өргөтгөл хийхдээ хэрэглэгчийн үйлчилгээг хязгаарлахгүй байх бүх арга хэмжээг авах ба зайлшгүй тохиолдолд үйлчилгээг хязгаарлах цаг хугацааны талаар хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.
 - 4.1.7 Үйлчилгээ үзүүлэгч нь төрийн удирдах дээд байгууллагын шийдвэр, гадаад, дотоод зах зээлийн үнийн өөрчлөлттэй уялдуулан үйлчилгээний үнэ тарифын уян хатан бодлого баримтлан түүнд нийцүүлэн үйлчилгээний үнэ тарифтаа өөрчлөлт оруулах эрхтэй ба энэ тохиолдолд заавал урьдчилан мэдэгдэнэ.
 - 4.1.8 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн байранд суурилуулсан кабелийн төгсгөлийн төхөөрөмж хүртэлх ашиглалтыг хариуцаж ажиллана. Хэрэглэгчийн дотоод сүлжээний төхөөрөмж болон түүний ашиглалтыг хэрэглэгч өөрөө хариуцах ба хэрэглэгчийн өгсөн дуудлагын дагуу компанийн ажилтан засвар үйлчилгээ хийвэл хавсралтад заасны дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ.
 - 4.1.9 Үйлчилгээ үзүүлэгч талаас шалтгаалаагүй хэрэглэгчийн дотоод сүлжээ, компьютер бусад төхөөрөмжийн техникийн гэмтэл, гэнэтийн саатлаас үүдэн үйлчилгээнд доголдол гарсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 4.2. Хэрэглэгчийн эрх үүрэг:
 - 4.2.1 Хэрэглэгч интернэтийн холболтын хурдаа зохих төлбөрийг төлсний үндсэн дээр өөрчлөх эрхтэй.
 - 4.2.2 Хэрэглэгч гэрээний Хавсралт №1-д заасан төхөөрөмжийн үнэ болон интернэт үйлчилгээний төлбөрийг төлөх ба тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойших үнэ болон интернэт үйлчилгээний төлбөрийг төлөх ба тоног төхөөрөмжийг хүлээн авснаас хойших түүний бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтлийг хариуцна.
 - 4.2.3 Хэрэглэгч нь өөрийн хүсэлтээр үйлчилгээг түр салгах тохиолдолд хаалгах, нээлгэх хугацааг тодорхой тусгасан албан хүсэлтээ ирүүлсний үндсэн дээр түр хаалгах ба 10 хоногоос дээш хоног хаалгасан тохиолдолд тухайн өдрүүд нь сарын төлбөрөөс хасагдаж тооцогдоно. Хэрэглэгч интернэтийн үйлчилгээг хаалгах буюу түр салгах хүсэлтээ _ өдрийн өмнө үйлчилгээ үзүүлэгч талд албан бичгээр мэдэгдэх ба мэдэгдээгүйгээс үүссэн төлбөрийг хэрэглэгч хариуцан төлнө.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно

4.2.4 Хэрэглэгч интернэт үйлчилгээ авч буй байрнаасаа нүүх, гэрээгээ шинэчлэх, цуцлах тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төвд гэрээний нэг хувь болон холбогдох бичиг баримттайгаа ирж, гэрээг шинэчлэх болон цуцална.

4.2.5 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс үйлчилгээ тасарсан тохиолдолд хэрэглэгч 99009529, 75991112 утсанд мэдэгдэж шалгуулна.

Тав. Нууц хадгалах

- 5.1 Талууд энэхүү гэрээг байгуулсан тухай болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бус замаар олж мэдсэн байгууллага, хувийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичсэн, аман болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.
- 5.2 Энэхүү гэрээний 5.1 -д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

Зургаа. Гэрээг өөрчлөх буюу цуцлах, сунгах

- 6.1 Дараах үндэслэлийн аль нэг нь байвал гэрээ дуусгавар болсонд тооцно:
 - 6.1.1 Аль нэг талаас цуцлах санал гаргаж талууд харилцан тохирсон баримтыг үндэслэж. Гэрээ цуцлах тухай саналаа 1 сарын өмнө бичгээр гаргана.
 - 6.1.2 Хуульд заасан бусад үндэслэлээр.
- 6.2 Талуудын удирдлага өөрчлөгдөх нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй.
- 6.3 Энэхүү гэрээ нь талуудын хооронд төлбөрийн үлдэгдэлгүй нь тогтоогдсоны дараа гүйцэд цуцлагдана.
- 6.4 Гэрээ цуцлагдсан нөхцөлд үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн төхөөрөмжийн үнийг нөхөн олгохгүй.
- 6.5 Гэрээг хэрэглэгчийн саналаар цуцалсан тохиолдолд тухайн сарын төлбөрийг буцаан олгохгүй.
- 6.6 Хэрэв аль нэг талаас гэрээг дуусгавар болгох саналаа 2.7 -д заасан сунгалтын хугацаа дуусахаас нэг сарын өмнө албан бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээг талууд харилцан тохиролцож цуцлах хүртэл хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 6.7 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай саналаа нэг сарын өмнө талууд албан бичгээр нөгөө талдаа мэдэгдэнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр/-ийн болон Хэрэглэгч талын өөрийн буруутай үйлдлээс учирсан хохирлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.
- 7.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс хий болсон нь 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 7.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

Найм. Маргааныг шийдвэрлэх

- 8.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 8.2 Санаал зөрөлдөөн маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.3 Энэхүү гэрээнээс үүсэх аливаа зөрөлдөөн маргааныг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно

Ес. Бусад зүйл

- 9.1 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 9.2 Талуудын удирдах зөвлөл , гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 9.3 Энэ гэрээнд шууд заагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.
- 9.4 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 9.5 Энэхүү гэрээ нь Талууд харилцан гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭГ БАТАЛГААЖУУЛСАН:

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж

Хэрэглэгчийг төлөөлж:

Нягтлан бодогч

Нягтлан бодогч

...../ /

...../

Хаяг: Булган аймаг, Булган сум, 5-р баг
Дамбын 1-р гудамж 136 тоот
Булган нэт ХХК

Хаяг: Булган аймаг, Булган сумын
.....

Утас: 99009529
И-мэйл: tuvshuu100@gmail.com

Утас:
И-мэйл:

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно



2026 оны ...-р сарын ... өдрийн
ИҮГ 26/...-... тоот гэрээний Хавсралт №1

ИНТЕРНЭТИЙН УРСГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

№	Үйлчилгээний төрөл 1 сарын төлбөр	Үнэ /НӨАТ-тэй/ төгрөг
1	... mbps хүртэлх хурдтай интернэт төгрөг

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно